

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Иргэний хуулийн 123 дугаар зүйл, “Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “Банк” гэх)-ийн дүрмийн 8 дугаар 8.11.20 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Банкны холбогдох этгээд болох “TDB Capital Singapore” Pte. Ltd-д энэхүү тогтоолын хавсралтад заасан “Зээлийн гэрээний үндсэн зээлийг шаардах эрх”-ийг тус хавсралтад заасан нөхцөлөөр худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцлийн бусад нөхцөлийг тодорхойлж, гарын үсэг зурах холбогдох бусад баримт бичигт Банкныг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох гүйлгээг хийх болон шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА /2